



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 116

Мандалговь

Автомашинд дахин үнэлгээ тогтоож,
дуудлага худалдаагаар худалдах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлага худалдаа зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 10,094,220 (арван сая ерэн дөрвөн мянга хоёр зуун хорин) төгрөгийн балансын үнэ, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ДУА 23-90 улсын дугаартай УАЗ-пургон маркын автомашин, Сайнцагаан сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 18,000,000 (арван найман сая) төгрөгийн балансын үнэ, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ДУА 53-90 улсын дугаартай УАЗ-315122 маркын автомашиныг тус тус худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоож нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг хууль журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсаны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Мөнхтогтох, Сайнцагаан сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Нанжид нар тус тус даалгасугай.

Дөрөв: Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХТ-ийн 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 81 дугаар тогтоол, 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 57 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.

Тав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



0100282

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
 2010 оны 12 сарын 10-ний өдрийн
 116 дугаар тогтоолын хавсралт

Дахин үнэлгээ тогтоож, дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн жагсаалт

№	Байгууллагын нэр	Автомашин марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн / ашиглалтанд орсон он	Балансын үнэ	Анх тогтоосон үнэ		Шинэчлэн тогтоосон үнэ
					төгрөгөөр	төгрөгөөр	
1	Дэрэн сум Ерөнхий боловсролын сургууль	УАЗ-пургон, Дуга 23-90	1998/1998	10,094,220.00	1,000,000.00	1,000,000.00	500,000.00
2	Сайнцагаан сум Эрүүл мэндийн төв	УАЗ+315122, Дуга 53-90	2010/2010	18,000,000.00	3,000,000.00	3,000,000.00	2,000,000.00